



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А/179

Арвайхээр сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, 48 дугаар зүйлийн 48.2.4, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйлийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Үнэлгээний хорооны хуралдааны 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 01 дүгээр дүгнэлтийн дагуу БШУЯ/20240101029/01/01 урилгын дугаартай Спорт заалны барилга, 250 суудал (Өвөрхангай, Гучин-Ус сум) ажлыг 2,840,452,609 (хоёр тэрбум найман зуун дөчин сая дөрвөн зуун тавин хоёр мянга зургаан зуун ес) төгрөгөөр Өваргуйт-Эрдэнэ ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Тендерт шалгарсан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан, ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээн авахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Т.Ариунболд)-т даалгасугай.

3. Шалгарсан аж ахуйн нэгж санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн өгч, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Худалдан авах ажиллагааны газар (Ц.Идэрсайхан)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



И.ДОРЖСҮРЭН

6224 11 0384